

2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр

**ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ  
ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД**

Шинжээчээр хамтран ажиллах урилга хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Улсын төсвөөр санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж, баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах” сэдэвт аудитад “Барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл, төсөвт өртгийн нэмэгдлийн шалтгаан нөхцөлийг тодруулж, хянаж, дүгнэлт гаргах /Улаанбаатар хот, Өмнөговь, Дундговь аймаг” зорилгоор шинжээч сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан хамтран ажиллахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Шинжээч нь **ҮАГ-АД/2023-01** дугаар ажлын даалгаврын хавсралт **3-т** тусгагдсан **13** төсөл арга хэмжээ /задаргааг хавсаргав/-ний ажлын гүйцэтгэл, төсөвт өртгийн нэмэгдлийн шалтгаан нөхцөлийг тодруулж, хянаж, дүгнэлт гаргах зөвлөх үйлчилгээг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд хэрэгжүүлнэ.

Шинжээч нь төсөл, арга хэмжээ бүрээр дараах ажилбаруудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Барилга, байгууламжийн зураг нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах;
- Барилга, байгууламжийн төсвийг батлагдсан зургийг үндэслэн, холбогдох хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиосон байдалд дүгнэлт гаргах;
- Барилга байгууламжийн ажлыг магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхэд дүгнэлт гаргах;
- Барилга байгууламжийн төсөвт өртгийн нэмэгдлийг хянаж, магадлалаар баталгаажсан үнийн дүнгээр санхүүжүүлэх боломжтой эсэхийг тогтоох, эсвэл санхүүжүүлэх бодит дүнг тооцоолж, дүгнэлт гаргах;
- Барилга угсралтын ажлын гүйцэтгэл, санхүүжилт болон төсөвт зөрүү илэрсэн тохиолдолд зөрүүг төсвийн программаар тооцоолон тогтоож, дүгнэлт гаргах;

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажилбаруудыг төсөл, арга хэмжээ бүрээр, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, барилга, байгууламжийн зураг, төсөв, гүйцэтгэл, санхүүжилт, төсөвт өртгийн нэмэгдэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, норматив, стандартын шаардлагуудтай нийцсэн эсэхийг хянаж, гарсан үр дүнг тусгасан мэргэжлийн дүгнэлт бүхий тайланг бэлтгэж, Улсын төсвөөс санхүүжүүлэх боломжтой нэмэлт төсвийн дүнг “Төсвийн тооцооны программ”-аар тооцоолж, гарсан үр дүнг тайланд хавсаргаж, тайланг гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

Мэдүүлгээ ирүүлж буй хувь хүн/баг/, хуулийн этгээд нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт ирүүлэхээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

**Хуулийн этгээд бол:**

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт /цахимаас татан авсан/;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/цахимаас татан авсан/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр

/2020,2021, 2022 он/;

- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021 он/

**Хувь хүн/баг бол:**

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багаар ажиллах бол хамтран ажиллах гэрээ байгуулан нотариатаар баталгаажуулан ирүүлэх /багийн ахлагчийн мэдээллийг тусгайлан ирүүлэх ба гэрээнд багийн ахлагч, гишүүдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлсон байх/;

Шинжээч нь барилга, байгууламжийн зураг төсөл, боловсруулах, дүгнэлт гаргах эрх бүхий, төслийн эдийн засгийн үр өгөөж, үр дүнг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн, барилга, байгууламжийн зураг төсөл, магадлалын чиглэлээр дүгнэлт гаргаж байсан, ажлын гүйцэтгэл, төсөвт өртгийг хянан, мэргэжлийн түвшинд дүгнэлт гаргаж чадахуйц, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага туршлагатай, иргэн, хуулийн этгээд /түншлэл байж болно/ байх бөгөөд зөвлөх үйлчилгээг багаар үзүүлнэ. Үүнд:

- Багийн ахлагч:

Барилгын инженер, Монгол Улсын зөвлөх инженер эсвэл Тэргүүлэх төсөвчин, мэргэжлээрээ 12 ба түүнээс дээш жил ажилласан, судалгаа шинжилгээний болон шинжээчийн ажлын туршлагатай байх;

- Багийн гишүүд:

Тэргүүлэх төсөвчин эсвэл мэргэшсэн төсөвчин, мэргэшсэн инженер, мэргэжлээрээ 8 ба түүнээс дээш жил ажилласан, шинжээчийн ажлын туршлагатай байх.

Мэдүүлэг ирүүлж буй шинжээч нь хавсралтад тусгагдсан ажлуудын зураг төсөл, төсөв, ажлын гүйцэтгэлд оролцсон, хянасан, дүгнэлт гаргасан эсхүл гэрээг хянах зөвлөхөд нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол санал ирүүлэх боломжгүй болохыг анхаарна уу.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгээ 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 09 цаг 30 минутын дотор /[tsend-ayushn@audit.gov.mn](mailto:tsend-ayushn@audit.gov.mn), [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn) / цахим хаягаар pdf файл хэлбэрээр ирүүлнэ үү. Хариуцсан ажилтан: Үндэсний аудитын газрын Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. Гар утас: 88051068

Захиалагчийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,  
Засгийн газрын IV байр, 305 тоот өрөө. Үндэсний Аудитын газар. Утас: 51-26 17 45.

[www.audit.mn](http://www.audit.mn)

**Шинжээчийн дүгнэлт гаргах барилга байгууламжийн жагсаалт /БАГЦ-3/**

**сая төгрөг**

| №  | Төсвийн<br>ерөнхийлөн<br>захирагч    | 2023 оны Төсвийн тухай хуулиар                                                                                                           |                  |        |              |
|----|--------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|--------|--------------|
|    |                                      | Төсөл, арга хэмжээний нэр, байршил                                                                                                       | Хэрэгжих хугацаа |        | Төсөвт өртөг |
|    |                                      |                                                                                                                                          | Эхлэх            | Дуусах |              |
| 1  | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Сургуулийн барилга, 640 суудал, спорт<br>заал /Дундговь, Сайнцагаан сум/                                                                 | 2022             | 2024   | 9,480.1      |
| 2  | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Сургуулийн дотуур байрны барилга, 80<br>ор /Дундговь, Говь-Угтаал сум/                                                                   | 2022             | 2023   | 1,569.8      |
| 3  | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Сургуулийн барилга, 960 суудал<br>/Дундговь, Сайнцагаан сум, Говийн<br>ирээдүй цогцолбор/                                                | 2021             | 2023   | 5,987.9      |
| 4  | ЭРҮҮЛ<br>МЭНДИЙН<br>САЙД             | Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор<br>/Өмнөговь, Манлай сум/                                                                            | 2020             | 2023   | 1,919.9      |
| 5  | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 200<br>ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 198<br>дугаар цэцэрлэг/                                         | 2022             | 2023   | 4,449.4      |
| 6  | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Цэцэрлэгийн барилга, 240 ор<br>/Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг,<br>40 дүгээр хороо/                                                  | 2022             | 2023   | 2,854.0      |
| 7  | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Бага сургууль, цэцэрлэгийн барилга<br>/Улаанбаатар, Налайх дүүрэг, 6 дугаар<br>хороо/                                                    | 2021             | 2023   | 3,600.3      |
| 8  | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Цэцэрлэгийн барилга, 240 ор<br>/Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг,<br>42 дугаар хороо/                                                  | 2022             | 2023   | 2,769.8      |
| 9  | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр<br>барих, 240 ор /Улаанбаатар, Хан-Уул<br>дүүрэг, 10 дугаар хороо, 49 дүгээр<br>цэцэрлэг/            | 2022             | 2023   | 2,798.9      |
| 10 | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор<br>/Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 13<br>дугаар хороо/                                                | 2020             | 2023   | 4,693.0      |
| 11 | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Сургуулийн барилга, 320 суудал<br>/Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг,<br>10 дугаар хороо/                                               | 2020             | 2023   | 3,706.1      |
| 12 | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Бага сургууль, цэцэрлэгийн<br>цогцолборын барилга /Улаанбаатар,<br>Баянгол дүүрэг, 23 дугаар хороо/                                      | 2020             | 2024   | 6,825.0      |
| 13 | БОЛОВСРОЛ,<br>ШИНЖЛЭХ<br>УХААНЫ САЙД | Сургуулийн барилгыг буулгаж, шинээр<br>барих, 960 суудал /Улаанбаатар,<br>Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар<br>хороо, 12 дугаар сургууль/ | 2021             | 2025   | 18,475.3     |